210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	665,969,132.82

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,599,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,599,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	916,754,566.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	916,754,566.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	110,205,092.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	806,549,474.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиг үүргийг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.1-д *“харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, Төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах, захиргааны болон төсөв, татвар, санхүүгийн удирдлага, зохион байгуулалтыг хангах, холбогдох байгууллага, иргэдэд мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх”* гэж тодорхойлсон.

Нийслэлийн Багануур Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагааны зорилгоо *“Бүтээн байгуулалтын жил болгох”* гэж тодорхойлон дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хуулиа дээдлэн, салбар хоорондын хамтын ажиллагааг эрхэмлэн цахим засаглалын бодлогыг хэрэгжүүлэх;
- Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын тамгын газар нь байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэл тайлагналд МУ-ын Үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ, Төрийн хэмнэлтийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Аудитын тухай хууль, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Татварын ерөнхий хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль, Архив албан бичиг хэрэг хөтлөлтийн тухай хууль, болон бусад тогтоомж, журам, шийдвэрүүдийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант онд дараах хууль, тогтоомж, болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт;

- Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт;
- ЗГ-ын 2025 оны 17 дугаар тогтоол “Төрд учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаал “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаал “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай”

Тайлант онд мэргэжлийн хяналт шалгалт болон дотоод хяналт шалгалт хийгдээгүй. Нийслэлийн дүүргийн Дотоод аудит албанаас 2025 оны 9 сар хүртэлх хугацааны хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтын үр дүнг 2 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 188,845.1 мянган төгрөгийн зөрчилд 188,845.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлбэл зохих 42,479,522.4 мянган төгрөгийн 681 мэдээллээс 681 мэдээлэл бүрэн оруулсан боловч 122 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 73 гүйлгээг, өмч, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 49 шийдвэрийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.4.4-т *"таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"*, 6.4.8-д *"бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн*

түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод тухай бүрд байршуулж байх зөвлөмж өгөв.

4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАУХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд тайлант онд батлагдсан төсвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ, гүйцэтгэлийн тайланг цахим систем (www.tender.gov.mn)-д ил тод мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,663,800.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,663,800.7 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Тооцоолсон цалин хөлс, нэмэгдэл цалин, суутгалын дүнг анхан шатны баримт, ерөнхий журнал, санхүүгийн тайлантай тулгахад дансны бичилт цалингийн хүснэгтээс 895,794.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 768,006.7 мянган төгрөгөөр дутуу, алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2. "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" заалттай нийцээгүй, АОУС-450 "Аудитын явцад илрүүлсэн буруу илэрхийллийг үнэлэх А9. "Аудиторын танилцуулсан буруу илэрхийллийг оролцуулаад бүх буруу илэрхийллийг удирдлага залруулах нь нягтлан болох бүртгэл хөтлөлт, бичилтийг зөв хийх, өмнөх үетэй холбоотой материаллаг бус залруулагдаагүй буруу илэрхийллийн хуримтлагдсан үр нөлөөний улмаас ирээдүйн санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэл гарах эрсдлийг бууруулах боломжийг удирдлагад олгоно" стандарт болон санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 228,870.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,511.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 188,845.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 38,514.2 мянган төгрөгийн 6 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 228,870.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.1 Төлбөрийн акт

1. Гадаад томилолтын зардлаас БНХАУ-д туршлага солилцоход 14 албан хаагчдад 21,160.0 мянган төгрөг зарцуулснаас 1,511.4 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй, илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д *"хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"* заасантай тус тус нийцээгүй, УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга MNS-6817-4:2020 стандарт болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ бүртгэхгүй, холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Төсвийн хөрөнгөөр ижил нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хуулийг хэрэгжүүлээгүй, шууд гэрээ байгуулж 188,845.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 *"Хариуцлагатай байх"*, 6 дугаар зүйлийн 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т *"Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"*, 10.5-д *"Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно"*, 31 дүгээр зүйлийн 31.1-т *"Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, шууд гэрээ байгуулж, хөрөнгө зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал:

Илрүүлэлт 1: Анхны өртгөө нөхөж үлдэгдэл өртөггүй болсон 214 нэр төрлийн 387 хөрөнгийг (275,650.9 мянган төгрөг) акталж устгаагүй, цаашид ашиглах хугацаа, үнэ үнэлгээг дахин үнэлээгүй, холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-д *"Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох"* заасантай тус тус нийцээгүй, УСНББОУС-30 "Санхүүгийн хэрэглүүр: тодруулга" стандарт болон санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэлтэй хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг бодитоор үнэлж цаашид ашиглах, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах ажлыг зохион байгуулах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 2: Нүүрс зарцуулалтын тайлангүй, зуухны галлагаат норм тодорхойгүй, өдөрт зарцуулсан нүүрсний тэмдэглэлгүй, эд хариуцагчаас олгосон хэмжээгээр 1,867.9 мянган төгрөгөөр зардалд тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"*, заасантай нийцээгүй, УСНББОУС 29 "Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт," стандарт болон санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Он удаан жил болсон 3,708.6 мянган төгрөгийн авлага, 12,514.0 мянган төгрөгийн өглөгийг шүүх, хууль хяналтын байгууллагын шийдвэргүйгээр данс бүртгэлээс хассан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах"*, 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"*, заасантай нийцээгүй, УСНББОУС 29 "Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт," стандарт болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шүүх, хууль хяналтын байгууллагын шийдвэргүйгээр авлага, өр төлбөрийг данс бүртгэлээс хасахгүй байх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 2: Төсвийг зөв зохистой удирдаагүй, цалингаас суутган тооцсон татварыг 14,031.8 мянган төгрөгөөр илүү төлж, авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, заасантай нийцээгүй, УСНББОУС 29 "Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт," стандарт болон

санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингаас суутган тооцсон шимтгэл, татварын тооцоог үнэн зөв бүрэн хийж, илүү төлөлт үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 3: Төсвийг зөв зохистой удирдаагүй, жилийн төсөвтөө багтаан 3,388.0 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", заасантай нийцээгүй, УСНББОУС 29 "*Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*," стандарт болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх, урьдчилан тооцоолж, судалгаанд хамруулж, санхүүгийн жилд багтаан барагдуулж байх зөвлөмж өгөв.

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгаврын хэрэгжилтийг хангаагүй 1,540.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авсан байна.

Энэ нь Ерөнхий сайдын 2025 оны 12 сарын 10 өдрийн 05 тоот "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгаврын 1.4.3 "*тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх*" заалтуудтай тус тус нийцээгүй, УСНББОУС 29 "*Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*," стандарт болон санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэн шаардлагатай бус зардлыг тэвчиж, төсвийн жилд баталсан албан даалгавар эрх зүйн актыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тооцоолсон цалин хөлс, нэмэгдэл цалин, суутгалын дүнг анхан шатны баримт, ерөнхий журнал, санхүүгийн тайлантай тулгахад дансны бичилт цалингийн хүснэгтээс 895,794.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	895,794.0			1	895,794.0	1	895,794.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 768,006.7 мянган төгрөгөөр дутуу, алдаатай тайлагнасан байна	1	768,006.7			1	768,006.7	1	768,006.7				
Дүн	1	1,663,800.7			1	1,663,800.7	1	1,663,800.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гадаад томилолтын зардлаас БНХАУ-д туршлага солилцоход 14 албан хаагчдад 21,160.0 мянган төгрөг зарцуулснаас 1,511.4 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй, илүү шилжүүлсэн байна.	1	1,511.4	1	1,511.4								
Төсвийн хөрөнгөөр ижил нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа шууд гэрээ байгуулж, 188,845.1 мянган төгрөгийн санхүүжилт, холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	188,845.1			1	188,845.1						
Анхны өртгөө нөхөж үлдэгдэл өртөггүй болсон 214 нэр төрлийн 387 хөрөнгийг (275,650,936.00 төгрөг) акталж	1	0					1	0				

устгаагүй, цаашид ашиглах хугацаа, үнэ үнэлгээг дахин үнэлээгүй, холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлээгүй байна.												
Нүүрс зарцуулалтын тайлангүй, зуухны галлагаат норм тодорхойгүй, өдөрт зарцуулсан нүүрсний тэмдэглэлгүй, эд хариуцагчаас олгосон хэмжээгээр 1,867.9 мянган төгрөгөөр зардалд тооцсон байна.	1	1,867.9					1	1,867.9				
Он удаан жил болсон 3,708.6 мянган төгрөгийн авлага, 12,514.0 мянган төгрөгийн өглөгийг шүүх, хууль хяналтын байгууллагын шийдвэргүйгээр данс бүртгэлээс хассан байна.	1	16,222.6					1	16,222.6				
Төсвийг зөв зохистой удирдаагүй, цалингаас суутган тооцсон татварыг 14,031.8 мянган төгрөгөөр илүү төлж, авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна.	1	14,031.8					1	14,031.8				
Төсвийг зөв зохистой удирдаагүй, жилийн төсөвтөө багтаан 3,388.0 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна	1	3,388.0					1	3,388.0				
Дүн	8	228,870.7	1	1,511.4	1	188,845.1	6	38,514.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 73 гүйлгээг, өмч, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 49 шийдвэрийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	0			1	0						
Нийт дүн	1	0			1	0						



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 дугаар сарын 15

№ 103/А0220181

Улаанбаатар хот

ММН-2026/403/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад томилолтын зардлаас БНХАУ-д туршлага солилцоход 14 албан хаагчдад 21,160.0 мянган төгрөг зарцуулснаас 1,511,400.00 (нэг сая таван зуун арван нэгэн мянга дөрвөн зуу) төгрөгийн анхан шатны баримтгүй, илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гадаад томилолтын зардалд илүү шилжүүлсэн 1,511,400.00 (нэг сая таван зуун арван нэгэн мянга дөрвөн зуу) төгрөгийг Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Баттүшиг, ерөнхий нягтлан бодогч З.Эрдэнэцэцэг нараар төлүүлж, Багануур дүүргийн Төрийн сан банкин дахь НД.татварын бус орлогын MN560090100200200910 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Баттүшиг, ерөнхий нягтлан бодогч З.Эрдэнэцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
В.АЛТАНЦЭЦЭГ
Б.ТЭГШЛХАМ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110287



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 360/АД290181

Улаанбаатар хот

НТАГ-2026/403/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр ижил нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа 188,845,100.00 (нэг зуун наян найман сая найман зуун дөчин таван мянга нэг зуу) шууд гэрээ байгуулж шилжүүлсэн, холбогдох хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлын 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5-д "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна" заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийг зөрчиж шууд гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Баттүшиг), ерөнхий нягтлан бодогч (З.Эрдэнэцэцэг) нарт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Б.ТЭГШЛХАМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090795